



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016. оны 07 сарын 04 өдөр

Дугаар Д/40.

Улаанбаатар хот

Баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай
жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2, 78.3, газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Хүннү гүрний 2225, Их Монгол улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр нийслэлийн нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд, гадаадын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, байгууллагын өрөө тасалгаа, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор үндэсний их баяр наадмын өдрүүдэд буюу 2016 оны 07 дугаар сарын 11-нээс 15-ны өдөр ажиллах ажилтнуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Баярын өдрүүдэд тус газрын эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлаар шуурхай шийдвэрлэх нөхцөл байдал үүссэн үед газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажиллах хариуцлагатай жижүүрт мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг нийт ажилтнуудад, төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй долоо худагт жуулчдын аюулгүй байдал, мэдээллээр шуурхай хангах, зохицуулж, хяналт тавьж ажиллахыг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Б.Жаргалан/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 07 сарын 04 өдрийн
А/70 дугаар тушаалын хавсралт



**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮЕЭР АЖИЛЛАХ
АЛБАН ХААГЧДЫН ХУВААРЬ**

№	Хийж хэрэгжүүлэх ажлууд	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Ажиллах цаг
1	Хүй долоон худагт жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, явуулын мэдээллийн цэг ажиллуулах	07 дугаар сарын 11,12, 13-ны өдрүүдэд	П.Баясгалан С.Баяржаргал	09:00-18:00
2	Төв цэнгэлдэх хүрээлэнд жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, явуулын мэдээллийн цэг ажиллуулах	07 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд	М.Чинсанаа Н.Алтанзаяа	09:00-18:00
3	Баяр наадмын нээлтийн үеэр 3 дугаар хаалган дээр ажиллах	07 дугаар сарын 11-ний өдөр	Д.Ганболд Б.Ербахыт Б.Халиун Ш.Ундармаа	08:00-12:00
	Баяр наадмын нээлтийн үеэр 4 дүгээр хаалган дээр ажиллах		Б.Жаргалан М.Чинсанаа Б.Амарзаяа	
	Баяр наадмын нээлтийн үеэр 15 дугаар хаалган дээр ажиллах		М.Болортуяа М.Баасандорж Ө.Ариунтунгалаг	
	Баяр наадмын нээлтийн үеэр 16 дугаар хаалган дээр ажиллах		С.Туул Э.Мөнхзул Д.Монголхүү Э.Золзаяа	
4	Чингисийн талбайд /Дээлтэй монгол наадам/	07 дугаар сарын 10-ны өдөр	Бүх ажилтнууд	15:00-20:00
5	Мэдээлэл сурталчилгааны төвд хариуцлагатай жижүүрээр ажиллах	07 дугаар сарын 11-ний өдөр	Э.Болорцэцэг	09:00-18:00
		07 дугаар сарын 12-ны өдөр	Б.Амарзаяа	09:00-18:00
		07 дугаар сарын 13-ны өдөр	М.Чинсанаа	09:00-18:00
		07 дугаар сарын 14-ны өдөр	С.Баяржаргал	09:00-18:00
		07 дугаар сарын 15-ны өдөр	П.Баясгалан	09:00-18:00